МЭДЭЭ · 2019 оны 12-р сарын 17

СУРАГЧДАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЯРИА ТАНИУЛГА ХИЙЖЭЭ



Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Сум дундын прокурорын газар болон тус сум дахь Сум дундын шүүх хамтран "Хүний эрхийн өдөр"-ийн хүрээнд ерөнхий боловсролын II сургуулийн 6-12 дугаар ангийн сурагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа, таниулга хийжээ.



Яриа, таниулгыг хяналтын прокурор Д.Ганчимэг "Харилцаа, хандлага ба гэмт хэрэг, зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх нь", шүүгчийн туслах А.Аззаяа "Хүүхдийн эрх" сэдвээр тус тус хийж, сэдвийн хүрээнд сурагчдын дунд асуулт, хариултын "АХА" тэмцээн зохион байгуулсан байна.


АЗ ЖАРГАЛТАЙ


ӨРГӨМЖЛӨЛ



Тэмцээнд 12а ангийн сурагч А.Ундармаа, С.Нэргүй нар хамгийн олон асуултанд зөв хариулж, анги хамт олноо тэргүүлжээ.

ХАНБОГД СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2918